

МОНГОЛЫН НЕОЛИТЫН ХҮМҮҮСИЙН ЭРХЛЭХ АЖ АХУЙН ТУХАЙ ТОВЧХОН

Ё.Баатарбилэг

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Антропологи-Археологийн тэнхим, магистрант. Baatarbileg@presi.pmis.gov.mn

Түлхүүр үг: Чулуун зэвсэг, түүвэрлэх аж ахуй, мал аж ахуй, газар тариалан

Монголын эртний түүхийн зангилаа асуудлуудын нэг нь Монголын неолитын үеийн хүмүүсийн эрхэлж байсан аж ахуйн хэлбэрүүд, тэдгээрийн хамрах бүс нутгийн хүрээ, хоорондын харилцан хамаарлын асуудал юм.

Энэ үеийг манай түүхч эрдэмтэд “олзворлох түүвэрлэх аж ахуйгаас үйлдвэрлэх аж ахуйд шилжсэн үе” гэх буюу “хэрэглэх аж ахуйгаас үйлдвэрлэх аж ахуйд шилжсэн үе” гэх зэргээр нэрлэдэг. Сүүлчийн нэр томъёо нь хэдийгээр ихээхэн шүүмжлэлд өртдөг ч гэсэн монгол хэлний, нэр томъёоны үгийн санаа, утгын гүнийг мөрдөн хөөж, хөрвөөн тайлбарлахад энэ 2 нэрийг агуулах утга нь адилдаа адил санагдана.

Ямар ч гэсэн энэ үеийг “неолитын хувьсгалын үе” гэж Английн нэрт эрдэмтэн Гордон Чайлд оновчтой нэрлэсэн билээ. Үнэхээр “Монголын неолитын үеийн олон олдвор тухайн үеийн хүмүүсийн соёл, иргэншилд асар хурдацтай өөрчлөлт гарсныг харуулж байгаа, үүнд “үйлдвэрлэгч аж ахуй” газар тариалан, мал аж ахуй үүссэн, эхийн эрхэт ёсны цэцэглэлт болсон, технологийн “шинэчлэлт” /чулууг өнгөлөх, зүлгэх, нүхлэж цоолох, ваар сав хийх/, гарсан нь археологийн шинжилгээний дүнгээр батлагдаж байна /Монгол улсын түүх. 1999, 40х/.

1.Газар тариалан

Монгол нутагт газар тариалан дэлхийн олонхи ард түмнүүдийн нэгэн адил идэвхтэй түүвэрлэн цуглуулах ажлаас үүдэн гарсан юм. “Неолитын хүн ургамлыг авч ашиглаж байсан туршлагыг судалсан нь бага боловч Монголын неолитынхон жимс, мөөг, сонгино, элдэв төрлийн амтат үр будааны ургамлыг ашиглаж байсан нь мэдээж. Байгалийн нөөц баялаг, идшинд хэрэглэж болох хар, шар будаа мэтийн төрөл бүрийн үр ургамал элбэг байсан нь Монгол нутагт газар тариалан эрт үеэс үүсэн гарч болох бодит нөхцлийг бүрдүүлсэн байна” /Н.Сэр-Оджав. 1977. 15 х/.

Монголын неолитын үеийн газар тариалан эрхлэлтийн талаар судлаачид зохиол бүтээлүүддээ нэлээд авч үзсэн байдаг. “Судалгааны дүнгээс харахад Монголд оршин суугчид нь орон нутгийн зэрлэг ургамлыг олон арга хэлбэрээр хэрэглэх /ашиглах/, анхдагч боловсруулалт хийх өөрийн гэсэн өвөрмөц арга барилтай байжээ. Тухайн цаг үед элсэнд таана, шар бударгана, сульхир, гоёо, нуур болон голын эргээр бас талд хармаг, хөмүүл, сонгино, мангир, гогод, улаан төмс, мөөг, нохойн хошуу ургадаг байв.

Н.М.Пржевальский, Алашаны Монголчуудын сульхир хэрэглэдэг талаар: Сульхир нь монголын мал сүрэгт сайн тэжээл болохоос гадна Алашаны Монголчуудын хүнсний гол бүтээгдэхүүн нь болдог. Алашанчууд намар 9 сард өөрийн элснээс арвин их ургацаа хураан авдаг гэж бичжээ. Ордосын Монголчууд газар тариаланг эрхэлдэг бөгөөд зэрлэг үр үндэс тэдний хоол хүнсэнд чухал үүрэгтэй. Түүний дотроос Ордосчуудын өөрсдийн нь нэрлэснээр чультур маш гол байрыг эзлэх ба түүнийг хоёр сортод хуваадаг. Бургут ба чультур гэнэ. Эдгээр ашигтай үр ургамлаас гадна өөр янз бүрийн жимс /говьд нутгийн ардууд нь жимсийг нэлээд түүдэг/ мөөг, таана, Алтайн гогод, сармис, монгол лууванг түүж хоол хүнсэндээ хэрэглэдэг. Түүвэрлэх аж ахуй нь өөрөө маш эртний уламжлалтай. Түрүү неолит, бүр эрт мезолит, палеолитын үеийн Монгол нутагт амьдарч байсан хүмүүс /байгал цаг уурын тааламжтай нөхцөлд/ идэвхтэй түүвэрлэгчид байв. НТӨ

3000-2000-ны үеийн Дорнод Монголд зөөлөн дулаан уур амьсгалтай байж, байгал цаг уурын тохиромжтой байдал, орон нутгийн зэрлэг ургамал нь хожмын таримал ургамал бий болох үндсэн нөхцөл нь болсон. Ийм байдал нь Дорнод Монголд харьцангуй эрт цагт газар тариалан эрхлэх боломжтой байсныг гэрчилнэ" /Д.Дорж. 1971. 84-85х/. Газар тариалангийн тухайд В.В.Волков: Неолитын үе ба хүрлийн түрүү үеийн байгал цаг уурын тааламжтай нөхцөл байдал нь түүвэрлэх аж ахуй эрчимтэй, өргөн хүрээтэй хөгжих үндэс нь болсон бөгөөд БНМАУ-ын өмнөт нутагт эрт цагт газар тариалан эрхлэх болсон гэж үзсэн байна.

Ер нь газар тариалангийн холбогдолтой багаж зэвсгүүд Монголын нутагт нэлээд элбэг тохиолдоно. Ялангуяа Дорнод Монголын олон бууц, суурингаас цайруулах самбар, анжисны хүндрүүлэгч, нүдүүр гэх мэт олддог. 1967-1969 онд Монгол-Зөвлөлтийн хамтарсан экспедицийнхэн Дорнод, Сүхбаатар аймгуудын нутгаас дээрхийн адил багаж зэвсэг нэлээдийг олсон. Чойбалсан хотын музейд Дөрвөн толгойгоос олдсон /Чойбалсан хотоос баруун хойш 100 км-т/ газар тариалангийн багаж зэвсгийн цуглуулга байдаг. Үүнд нэг самбар чулуу, нэг нүдүүр, хоёр жүн байна. Самбар чулууг саарал занарлаг чулуугаар хийсэн, ажлын гадаргуу нь маш сайн өнгөлөгдсөн байв. Нүдүүрийг нь бараан саарал занарлаг чулуугаар хийжээ. Баруун-Урт хотын музейд хоёр самбар чулуу, хоёр нүдүүр нэг жүн байдаг. Үүний нэг самбар чулууг нь нэг нүдүүрийн хамт аймгийн төвөөс олсон бөгөөд самбар чулуу нь маш том хэмжээтэй, ажлын гадаргуу нь сайтар өнгөлөгдсөн байдаг. Тиймэрхүү олдворууд бас Сайншанд хотын музейд бий. Үр тариа цайруулах самбар чулуу нь Дорнод Монголын бараг бүх газраас олддог нь энэ бүсэд неолитын овог аймгууд газар тариаланг өргөнөөр эрхэлж байсныг харуулна. Тамсагбулагийн газар тариалангийн чулуун зэвсгийн судалгаа нь дээрх дүгнэлтийг мөн батална.

Бүх өгөгдлүүдээс үзэхэд хожуу неолитын үед Дорнод Монголын овог аймгуудын аж ахуйд газар тариалан гол үүрэгтэй байжээ.

Монголын нутагт газар тариалан үүссэн явдлыг гадаад дотоодын зарим эрдэмтэд Хятадын нөлөө буюу эсхүл Хятадаас зээлдэн хэрэглэсэн явдал гэх мэтээр үздэг. Үүний эсрэг саналыг манай нэрт археологич Д.Дорж судалгааныхаа ажлын дүнд боловсруулжээ. Үүнд: "1.Хятадад бүр Яншао ба Луньшанаас эхлэн гол болгож тутрагыг тариалах болсон бөгөөд тутрагыг цайруулах хэрэгцээгүй байсны улмаас Монголд элбэг олддог үр тариа цайруулах самбар чулуу, нүдүүр, нухуур Хятадын нутгаас маш ховор олддог. 2.Монгол ба Яншао, Луньшаны соёл нь үндсээрээ өөр юм. Монголд неолитын өмнөх үеэс уламжлан ирсэн залтсан зэвсгийн соёл ноёрхож байсан бөгөөд Монголын неолитын үеийн орон сууцны байгууламж нь хүртэл Яншаогийнхаас өөр байна. 3.Монголын тариалах ургамал нь Монгол амуу буюу шар будаа байсан бөгөөд түүний зэрлэг дүрс нь одоог хүртэл байна" /Д.Дорж. 1971. 86-87х/ гэжээ. Дээрхээс үзэхэд Монгол нутагт газар тариалангийн ажил бие даан, гадны ямар нэг нөлөөгүйгээр үүсэн гарсан гэж үзэх болох юм.

"Газар тариалан үүсэн гарсан явдал нь бүр неолитын үед оршин суугчдын аж ахуйд чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд ан хийж ургамлын дүрс цуглуулан хэрэглэх зэрэг түр зуурын тэжээлээс хүнсний тогтмол бэлтгэлтэй байх бололцоог бий болгосон байна. Түүгээр ч барахгүй аж ахуйн шинэ хэлбэр болох газар тариалан нь хөдөлмөрийн багаж зэвсгээ сайжруулж аж ахуйгаа хөтлөх арга барилаа дээшлүүлэхэд зохих түлхэцийг өгсөн байна" /Д.Дорж. 1974. 127-131х/.

Монголын газар тариалантай холбогдуулан дурдах нэг зүйл бол Төв Азид неолитын үед эхлэл нь тавигдаж хүрлийн үе өргөнөөр тариалж байсан шар будааны тархалтын асуудал юм. Судалгааны зохиолоос үзэхэд неолитын хожуу үеэс Европт хүрсэн нь Украины Триполл, Румыны Боян /Румын ба Молдавийн заагдах Боян нуурын нэрээр нэрлэгдсэн археологийн соёл. НТӨ 4000-ны үед холбогдоно. Суурингийн үлдэгдэл, хээ бүхий ваар сав гэх мэт. Эрхлэх аж ахуй нь

газар тариалан, мал аж ахуй, ан агнуур ба загасчлал/, Македоны Вардар /Югослав ба Грекийн нутгаар дамжин Эгийн тэнгист цутгадаг голын нэрээр нэрлэгдсэн археологийн соёл. Газар тариалан, мал аж ахуй эрхэлдэг неолитын овог аймгууд. НТӨ 3500 орчим жилийн үед холбогдоно/, Грекийн Фессалийн соёлын суурин, мөн Унгарын Бюккийн соёлын дунд давхрагаас шар будаа олдсон ба Швейцари, Германы нутгаас олдож байна. Бас Төв Европын Лужицын /хожуу хүрэл, түрүү төмрийн үе. НТӨ 13-4-р зуун. Германы Лужицын тойргийн нэрээр нэрлэгдсэн. Хотхон, сууцны үлдэгдэл, бунхнууд. Газар тариалан ба мал аж ахуй эрхэлдэг. Оршин суугчид нь хожмын Славянчуудын уг гарвал байж магад/ хүний гол хүнс байжээ. Үр тариа цайруулах самбар чулуу Өмнөт Оросын нутгаар дамжин мөн л Европт хүрсэн бололтой. Триполлын соёлын сууцны НТӨ 3-р зууны сүүл үед холбогдох давхрагаас, чулуун самбар дээр чулуугаар үр тариа цайруулж буй эмэгтэй хүний дүрс бүхий шавар баримал олдсон.

Газар тариалангийн тухай ярихад хөдөлмөрийн багаж, тариалах ургамал, газрын хөрсний шим, ус зэргийн нөөц бололцоо нь тухайн үеийн шатанд ямар байсныг анхаарч асуудлыг тавих хэрэгтэй юм.

Газар тариаланг зохих хэмжээгээр эрхэлж байсан Монголын Дорнод хэсгийн бүс нутаг нь бэсрэг уулс, дов толгод зонхилсон, дэлхийн их мөсжилтүүдийн нөлөөнд ороогүй, гадаргын ил буюу ундармал ус ховор, мөнхийн хуурайдуу нутаг юм. Жилийн температурын хэлбэлзэл ихтэй /дунджаар $-30 - +30^{\circ}\text{C}$ /, өвөл нь цас бага унадаг /12 см орчим/, зун нь хур бороо ховор, 6 сарын эхнээс 8 сарын дунд үе хүртэл 180-200 мм тунадас унадаг, ан амьтан элбэг, уурагт ба цардууллаг үр үндэс бүхий ургамал ихтэй хахир хавар, налгар намартай. Яг ийм нөхцөлд неолитын хүн газар тариалан эрхлэхэд нэлээд эртдэх юм гэж академич О.Шагдарсүрэн үзэж байна. /1997. 35-39х/. Тэрээр Дорнод аймгийн Матад сумын нутаг Гашууны худаг гэдэг газраас 1938 онд олдсон неолитын үеийн чулуун самбар, нүдүүрийн олдвор дээр үндэслэн судалгаа хийгээд дээрх олдвор нь үр тариаг цайруулах зориулалттай бус харин зэрлэг ургамлыг хүнсэндээ хэрэглэхэд ашигладаг байсан гэж үзсэн. Энэ дүгнэлтээ тэрээр батлахдаа "неолитын хүн газар хагалж байсан гэх багаж хэрэгсэл одоогоор олдоогүй бөгөөд газар хагалж үр суулган тарьж идэхээс байгалийн зэрлэг ургамлыг түүж идэх нь хялбар байсан... Иймд зэрлэг ургамлыг өдөр тутмын хүнсэнд хэрэглээд зогсохгүй, тэдгээрийг ихээр нөөцөлж байжээ. Ингэж нөөцөлсөн үр жимс хатаж сэврэн шууд идэх боломжгүй болох бөгөөд уг хатсан ургамлыг бяцалж нунтаглахын тулд чулуун нидрүүл зайлшгүй шаардлагатай болсон" гэж үзсэн /О.Шагдарсүрэн. 1997. 36х/. Тэрээр газар тариаланг хүрлийн үед хамааруулан үзэж байгаа юм. Ямар ч байсан түүхэн бүх үеийг улируулан үзэхэд газар тариаланг эрхлэхэд тааламжтай экологийн хүчин зүйлүүд нь Монгол нутагт үргэлж хангалттай байж тариаланг хөгжүүлэх үндсэн нөхцөл нь болж чадсангүй. "Неолитын үед тариалах ургамал, үр тариа цайруулах самбар чулуу, газрын хөрс зэрэг нь /дээрхи эсрэгцсэн саналыг эс тооцвол/ тухайн үедээ тохирсон газар тариалан гэдэг ойлголтыг хангаж чадахуйц байсныг Хэрлэн голын савд олдсон бууцаар жишээлэн үзэж болох юм" /Н.Сэр-Оджав. 1977. 16х/. Түүнээс хойших үеүүдэд /тухайлбал хүрэл, төмөр, төрт улсуудын/ тариаланг хөгжүүлэх гэж оролдож байсан боловч бас л аж ахуйн биеэ даасан салбар болж чадсангүй. Монгол нутагт газар тариалан ийнхүү явц муутай байсан нь юуны өмнө газарзүйн хүчин зүйлээс ихээхэн шалтгаалж байгаа юм. Газрын хөрсний онцлог ба усны дутагдал, эх газрын эрс тэс уур амьсгал, ан агнуурын баялаг нөөц зэрэг нь тариалан хөгжөөгүйн гол шалтгаан байсан бололтой. Энэ нь Төв Азид нүүдлийн мал аж ахуй зонхилж, тариалан зөвхөн туслах үүрэг гүйцэтгэхэд хүргэсэн байна. Ямар ч гэсэн "НТӨ 3000-ны тэртээгээс хөдөлмөрийн анхдугаар том хуваарь болсон мал аж ахуйд шилжин орж тэр үеэс нүүдэлчид хэмээх ухагдахуун бий болжээ" /Н.Сэр-Оджав. 1981, 39 х/.

2. Мал аж ахуй

Мал аж ахуйн гарал үүсэл ба түүний хөгжлийн түрүү үеийн түүх нь нийт хүн төрөлхтний болон Монголын ард түмний нэн чухал асуудлуудын нэг юм.

“Мал аж ахуйн гарал үүслийн талаар 2 үндсэн чиглэлийн санал байдаг. Ихэнх судлаачид мал аж ахуй ба газар тариалан нь өөр өөр ард түмэнд бие биеэс хамааралгүй биеэ дааж үүссэн гэж үздэг байхад нөгөө хэсэг судлаачид, мал аж ахуй нь газар тариалангаас салбарлан хөгжсөн гэж үздэг” /Д.Цэвээндорж. 1992. 76х/. Судалгаанаас үзэхэд мал аж ахуй үүсч буй болоход аж ахуйн хэрэгцээ шаардлага үндсэн үүрэгтэй байсан гэдэг нь тодорхой. Үүний зэрэгцээ газарзүйн орчны тохиромжтой нөхцөл бүрэлдсэн нутагт мал аж ахуй, газар тариалан аль аль нь үүссэн голомт байж болох талтай. Нөгөөтэйгүүр зэрлэг амьтдыг өөр өөр нутагт, өвөрмөц нөхцөлд, янз бүрийн замаар, олон төрлийн зорилготойгоор гэршүүлж болох юм. Археологийн хэрэглэгдэхүүнд тулгуурлан монголын неолитын үеийн аж ахуйн асуудлыг судлахад газарзүйн асуудлыг салгаж болохгүй ба энэ үүднээс байгал-түүхийн ба геоморфологийн шинж чанараар Монгол нутаг нь уулархаг, өндөрлөг нутаг бөгөөд мал аж ахуйг хөгжүүлэхэд илүү зохицсон байна. Ялангуяа бэлчээрийн чадавхит талбай тариалангийнхаас илүү байсан нь мал аж ахуй голлож тариалан хавсрага үүрэг гүйцэтгэх болсны үндсэн шалтгаан юм.

“Судлаачид, мал аж ахуйн гарал үүсэл нь хөгжлийн гаршуулах ба гэршүүлэх гэсэн 2 үндсэн шаттай болохыг тогтоосон байна. Амьтдыг гаршуулах үйл явц нь байнгын бус шинж чанартай, янз бүрийн шалтгаанаар явагдаж болох боловч тогтмол амжилтанд хүрч байгаагүй юм. Харин амьтдыг гаршуулах практик үйл ажиллагаанаас шилэгдсэн цөөн төрлийн амьтад л гэршүүлэх үйл явцад хамрагдах болсон юм. Зээгт ав, амьтдыг хаших зэрэг нь тэдгээрийг гэршүүлэх гол арга нь байсан гэж үзэх үндэслэлтэй юм” /Д.Цэвээндорж. 1992. 77 х/. Түүх археологийн судалгаанаас үзэхэд Шинжаан, Дотоод Монгол ба Манжуурт 4500-4000 жилийн өмнө мал аж ахуйд шилжсэн болох нь тогтоогдсон. “Зөвлөлтийн эрдэмтэн Н.Н.Колесник /1949/ 2500 жилийн өмнө Сибирьт үхрийн аж ахуйг эрхэлж байсан ба Монгол, Киргиз, Казах, Сибирь, Якут, Сайет, Манжуурын үхэр сүргүүд нь бүгд Монгол-Тураны бүлэгт хамаарагдах нэг үүлдрийнх болохыг тэмдэглэсэн бөгөөд мөн ийм санааг В.И.Громова /1931/ гаргажээ” /Бат-Эрдэнэ. 1974. 343 х/. “Археологич В.Зайберт, Казахстаны Иман-Бурлук /Ишиман голын баруун цутгалан/ голын хөндийд НТӨ 4000-3000 жилийн үед холбогдох Ботайн сууринг малтахад тэндээс олон зуун адууны яс олдсон ба эртний амьтан судлаач-зоологичдын тогтоосноор тэдгээр нь зэрлэг болон гэрийн болгон дасгасан адууных байжээ. Тэрчлэн эрт дээр үеийн морины хазаар /psalia/ хэрэгсэл бас олдсон байна. Тэгэхлээр Казахстаны умарт хэсэгт НТӨ 3000 жилийн тэртээгээс адууг тэргэнд хөллөх зэргээр аж ахуйд хэрэглэж байжээ гэж үзэж болохоор байна” /Алишер Акишев. 2000. 12 х/. А.П.Окладников, А.П.Деревянко, Д.Дорж нар амьтдыг гэршүүлэх үйл явц болон Монгол оронд мал аж ахуй үүссэн он цагийг неолитын үед холбогдуулан үзэж байна. Монголын неолитын үеийн дурсгалууд, тухайлбал амьтдын ёслолын оршуулга /үхрийн эвэр, толгой, адууны ясыг Хэрлэн, Халх голын савд оршуулсан/ хадны зураг зэргийг А.П.Окладников судлаад Төв Азийн неолитын үеийн овог аймгууд адуу үхрийг бие даан гэршүүлсэн гэдэг дүгнэлтэнд хүрчээ. /А.П.Окладников. 1978. 199-204х/. Үхэр адууг зөвхөн Монгол нутагт төдийгүй бас хөрш зэргэлдээ улсуудын нутгуудад бусад гэрийн тэжээмэл амьтдаас түрүүнд гэршүүлсэн нь мэдэгдэж байна. “Неолитын үеийн Приморье ба Амар мөрний сав газруудад газар тариалангийн зэрэгцээ эхлээд гахай, дараа нь үхрийг, ялимгүй хожуу адууг өсгөн үржүүлж байсны ул мөр олдсон юм. Энэ нь Төв Азийн тал нутгийн /Монгол нутгийн/ овог аймгуудтай тогтоосон хэлхээ холбооны дүнд адуу мал өсгөн үржүүлсэн бололтой”. /А.П.Окладников/

3. Ан агнуур ба загасчлал

Шинэ чулуун зэвсгийн үеийн анчдын ул мөрийн олдвор Монголын бараг бүх нутгаас олддог. Археологийн материалаас харахад тэр үеийн анчид ойн буга, бор гөрөөс, хандгай, гахай, янгир, аргаль, талын зэрлэг адуу /хулан, тахь/ тэмээн гөрөөс, зээр болон бусад амьтад: тарвага, туулай, араатан шувуу зэргийг агнадаг байжээ. Неолитын үеийн анчдын ангийн багаж зэвсэг хурц ир, үзүүртэй, урьд урьдаас илүү нарийсан сайжирч нум сум нь хол тусгалтай болсны дээр оньст сааль, занга гэх мэт бий болжээ. Түүрүү неолитын дурсгалын нэг болох Жалган худаг ба Баянзагийн бууцуудад зэрлэг заан, үнэг, шувууны ясны олдворууд маш их олддог нь тэдгээр овгууд ангаар хүнснийхээ хэрэгцээний зохих хувийг хангадаг байсныг илтгэнэ. Дорнод Монголын түрүү неолитын үед ан агнуур, загасчлал аж ахуйн голлох хэлбэр нь байсан. Тэд нэг газраас нөгөөд нүүдэллэж ангийн шинэ сүргийг хайн олддог байв. Дорнод Монголын овгууд шалаш юмуу чума маягийн хөнгөн урц овоохойд амьдардаг байв. Энэ нь тэдний эрхэлж байсан аж ахуй болох ан агнууртай /загасчлалтай/ холбоотой. "Тэд нүүдлийн буюу хагас нүүдлийн хэв маягаар амьдардаг. Ангийн тухайд бол олон төрлийн зэр зэвсэг хэрэглэдэг. Нум сум, хутга, зуулган ир бүхий хутга, жад, кинжал, ангийн арьс боловсруулах хусуурхан зэргийг голчлон ашигладаг байжээ. Мөн ясаар жад, сумны зэв хийдэг байв. Тэдний хамгийн чухал зэвсэг нь нум сум юм. Хэрэв хүн гараар 30-40 м газарт шидэх бол нум сумаар 200-300 м газарт сайн харвадаг ба минутад 20 хүртэл харвах боломжтой. Томоохон араатан амьтдыг харвахаас гадна занги тавих аргаар агнадаг байжээ. Ангийн нэг төрөл нь шувууны ан байсан нь Овоот ба Тамсагбулагийн бууц суурингийн олдворуудаас харагддаг. Гол мөрөн ба нуур хөлдөх үеэр нисдэггүй шувууд болох галуу ба бусад шувуудыг харван агнадаг байсан бололтой бөгөөд нум сум нь хол тусгалтай байжээ. Ан агнуур нь Дорнод Монголын түрүү неолитын овгуудын аж ахуйн тэргүүлэх салбар яах аргагүй мөн байв" /Д.Дорж. 1971, 79-80х/. Зөвхөн энэ бүс нутаг төдийгүй Монголын бусад нутгаас олдсон түрүү неолитын бүх бууц, суурингуудад энэ байдал ажиглагддаг. "Тамсагбулагийн неолитын бууцнаас олдсон олдворуудаас харахад эндхийн овгууд нь ан агнуур эрхэлдэг байжээ. Эндээс сумны чулуун зэв ба ясан зэвсгийн янз бүрийн хэлбэрийн олдворууд, ангийн арьс боловсруулахад зориулсан зэвсгүүд ба ан амьтны яснууд ихээр олджээ. А.П.Окладниковын үзэж байгаагаар ан агнуур нь аль хэдийн мэргэшсэн хэлбэр болоод байсан гэжээ. Зарим нэг загасны яс ба загас барих хэрэгслийн олдворууд нь, загас агнуур тэр үед аж ахуйн гол хэлбэрүүдийн нэг байсан гэж үзэхэд хангалттай бус юм" /Д.Дорж. 1974, 127-131 х/. Монголын Дорнод хэсэгтэй хил залгаа "Умарт Ази ба Дорнод Сибирьт неолитын үед хандгай, бор гөрөөс, буга агнагч тэнүүлч юмуу хагас тэнүүлч анчид амьдарч байв. Загас агнуур энд туслах чанартай байсны дээрээс аж төрөх ёсыг тодорхойлдоггүй агаад анчдын оюун санааны болон нийгмийн соёлд ямар нэг мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэггүй байжээ" /А.П.Окладников. 1985/. Дорнод Монголын хувьд иймэрхүү нөхцөл байдалтай байсныг үгүйсгэх аргагүй юм. Гэхдээ Монголын неолитынхон тодорхой хэмжээнд загасчилдаг байсныг археологийн олдворууд гэрчилнэ. Жишээ нь: Дорноговь, Сүхбаатар, Өмнөговь, Увс, Архангай зэрэг аймгуудын нутгаас загас шүүж барьдаг торны живүүр болох нүхтэй, нүхгүй чулуу, ясан сэрээ, загасны чулуун дүрс зэрэг олдсон. Мөн иймэрхүү төрлийн олдворууд Өвөр Байгал, Лена, Амар мөрний сав газруудын неолитын дурсгалуудад илэрдэг. "Алс Дорнотын неолитод амь зуулгын гол эх булаг нь далай тэнгисээс дамжин ирсэн загас барих ажил байсан. Амар мөрөн ба Приморьегийн хавьд гол мөрний эрэг дагуу газруудад хагас суулгасан бат бөх сууцнууд, чулуун зэвсгийн үеийн хүмүүсийн жинхэнэ суурингууд байв" /А.П.Окладников. 1985/.

Ер нь аливаа аж ахуйг эрхлэхэд тухайн нутаг орны байгал, цаг уур, газар зүйн хүчин зүйлс маш их нөлөөтэй. Ийм учраас Монголын нөхцөлд загас агнуур нь аж ахуйн голлох салбаруудын нэг нь болж хөгжих болжомж бага юм. Яагаад гэвэл

тус бүс нутгийн дийлэнх хувь нь гадаргын ил усгүй, томоохон нуур цөөрөмгүй байсан ч тэрээр гол мөрөн, нуурууд нь жилийн бараг ихэнх хугацаанд мөсөн хучлагатай байдаг. Неолитын үеийн загасны хэрэгсэл, олдворууд Монголын нутгаас маш ховор олддог нь дээрх дүгнэлтийн нэг баталгаа нь байж болох юм.

ДҮГНЭЛТ

1. Монголын неолитын хүний амьжиргааны эх үүсвэр нь эхэндээ нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд ан агнуур, түүвэрлэх аж ахуй байсан бөгөөд ан агнууртаа ихэвчлэн дунд болон жижиг биет амьтдыг агнадаг байжээ.

2. Монголын неолитын хүний анхны нь гэршүүлсэн мал нь адуу, үхэр, бог мал байсан бололтой.

3. Монголын неолит үйлдвэрлэх аж ахуйд шилжин орох эхэн үедээ Монголын бүх нутаг дэвсгэрт Ан агнуураас-Мал аж ахуйд шилжих, Дорнод ба Зүүн өмнөт нутагт Түүвэрлэх аж ахуйгаас-Газар тариаланд шилжин орох үйл явцууд зэрэгцэн явагдаж яваандаа Мал-аж ахуй-үйлдвэрлэлийн зонхилох салбар болсон байна.

4. Газар тариалан нь бүс нутгийн байгал цаг уурын онцлогоос шалтгаалаад /үүнд голоцены үеийн уур амьсгалын ерөнхий хандлагууд орно/ зарим үед идэвхтэй хөгжсөн боловч эцэстээ аж ахуйн бие даасан салбар болтлоо хөгжиж чадаагүй байна.

5. Ан агнуур ба загасчлал нь газарзүйн байрлалаас шалтгаалсан цөөнх овгийн эрхлэх аж ахуй болон үлдсэн бөгөөд энэ байдал нь саяхныг хүртэл хадгалагдаж байв.

6. Ер нь Монголын неолитын үйлдвэрлэх аж ахуйд шилжин орсон талаархи асуудлыг, ялангуяа Баруун ба Төв, Умарт Монголын неолитыг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байна.

Ном зүй

Алишер Акиев "Скифээс улбаалсан их торгон зам" 2000. УБ

Бат-Эрдэнэ. "К вопросу происхождения и историй местных пород скота в Монголии". В "Роль кочевых народов в цивилизации Центральной Азии". 1974. УБ

Дорж Д. "Неолит Восточной Монголии" 1971. УБ

Дорж Д. "Тамцаг-булагская культура и ее место древнейшей истории Центральной Азии". В "Роль коч. Нар. В цив. Ц.Азий." 1974. УБ

Монгол Улсын түүх. 1999. УБ

Окладников А.П. "Из области духовной культуры неолитических племен долины Керулена: Ритуальные захоронения остатков животных" в "Археология и этнография Монголии" 1978.

Окладников А.П. "Сибирийг нээсэн нь" 1985

"Советский энциклопедический словарь" 1985

Сэр-Оджав Н. "Монголын эртний түүх" 1977

Сэр-Оджав Н. "Монголын эртний түүхийн нэгэн агшинд" ШУА мэдээ сэтгүүл. 1981

Цэвээндорж Д. "Монголын мал аж ахуйн гарал үүслийн тухай асуудлыг хадны зургаар". ОУМЭ-ийн 5-р Их хурал. 3-р боть. 1992

Шагдарсүрэн О. "Худаг ба неолитын хүний экологийн асуудалд". Төв Азийн соёл иргэншлийн зарим асуудал. 1997

Summary

Yo.Baatarbileg

Subsistence economy of Mongolian in Neolit

Archeological findings play an important role in studying the characteristics of the transition to manufacture during the Neolithic Age in Mongolia. Those findings express, on one hand, the needs, aspirations, artistic skills, power and strength of the people who created them. On the other hand, they demonstrate the environment and geographical conditions, and how the people who lived during that time, adjusted to them.

When the writer chose this topic and conducted the research, he used the relevant books and materials on the Neolithic Age in Mongolia, as well as the research materials on the Neolithic Age in the Far East, Manchuria, and Internal Mongolia which border with Mongolia. The writer made the following conclusions during the process of writing the article. Those are:

- 1. The main source of living for all the people who lived during the Neolithic Age in Mongolia was hunting and collecting food. They hunted usually medium- and small-sized animals.*
- 2. The first domesticated animals of the Neolithic people probably were horses, cattle, and small livestock.*
- 3. During the initial stage of the transition to Neolithic manufacture the people throughout the territory of Mongolia made transition from hunting to livestock breeding, and the people living in the East and the South East made transition from collecting food to agriculture. Though these two processes were going simultaneously, with the time the livestock breeding has prevailed.*
- 4. The agriculture has been developed sometimes quite intensively due to the characteristics of the regional climate /these include the general climatic trends during the Holocene Age/ but ultimately it failed to develop into an independent economic field.*
- 5. Hunting and fishing have become an economic activity practiced by minority tribes dictated by their geographical situation. This trend has been being preserved until recently.*
- 6. In general, there is a need for further studies of the issues related with the transition to manufacture during Neolithic Age in Mongolia, particularly the Neolithic Age in the Western, Central and Northern parts of Mongolia.*